

"ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛ"-ИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ
/2019 оны 2 дугаар улирлын байдлаар/

2019.06.28

Булган аймаг

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2019 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
1. ИРГЭДИЙН ХЭРЭГЦЭЭНД СУУРИЛСАН ҮЙЛЧИЛГЭЭ							
1	1.1. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан иргэн төвтэй "ухаалаг үйлчилгээ"-г хөгжүүлэх	1.1.1. Төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг үе шаттай нэвтрүүлж, Төрийн цахим мэдээлэл солилцооны системд төрийн байгууллагуудыг холбох үйл ажиллагааг эрчимжүүлж, цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээний тоог нэмэгдүүлэх;	IV		Төрийн 35 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх	Улсын бүртгэлийн хэлтсээс иргэний бүртгэлийн үйлчилгээг 100% цахим хэлбэрт шилжүүлж иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай үзүүлэхээр хуулийн этгээдийн бүртгэлийг цахимжуулах ажлыг 2019 оны 02 дугаар сард бүрэн дууссан. Эхний хагас жилийн байдлаар хуулийн этгээдийн бүртгэл, лавлагааг цахимаар 280 гаруй иргэдэд үзүүлсэн. УБЕГ, Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй төслийн хүрээнд иргэний бүртгэлийн үйлчилгээг сумаас шууд үзүүлэх ажлын хүрээнд 8 сумын иргэний бүртгэлийг цахимжуулах ажлыг эхлүүлж, эхний хагас жилийн байдлаар 80%-ийн гүйцэтгэлтэй 07 дугаар сарын 01-ний дотор бүрэн дуусгахаар ажиллаж байна.	70
2		1.1.3. Орон нутгийн иргэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр авах боломжийг бүрдүүлж, 7 сумыг өндөр хурдны шилэн кабелийн сүлжээнд шинээр холбох;	III		16 сум, 1 тосгонд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр авах боломжийг бүрдүүлэх	Аймгийн 16 сум, 1 тосгон өндөр хурдны шилэн кабелийн сүлжээнд бүрэн холбогдсон. Сумд, байгууллагууд төрийн албан хэрэгцээний цахим программыг бүрэн ашиглаж байна. Улсын бүртгэлийн ерөнхий газар, Азийн хөгжлийн банктэй хамтран хэрэгжүүлж буй "Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор бүртгэлийн системийг боловсронгуй болгох" төслийн хүрээнд 8 сумыг нэгдсэн сүлжээнд холбох бөгөөд, үлдсэн сумдыг төсвийн хөрөнгөөр холбохоор бэлтгэлийг хангаж байна.	70
3		1.1.4. Төрийн үйлчилгээний "Цахим үйлчилгээний төв"-ийг орон нутагт байгуулах;	IV		16 сум, 1 тосгонд цахим үйлчилгээний төв-ийг байгуулна	Төрийн үйлчилгээний нэгдсэн "Цахим төв"-ийг байгуулах саналыг боловсруулан ЗГХЭГ-т хүргүүлсэн.	30
4	1.2. Төрөөс үзүүлдэг үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээний байгууллага бүр тоо хэмжээ, цаг хугацаа, чанар, өртөг гэсэн үзүүлэлтээр үйлчилгээний стандарт тогтоож хэрэгжүүлэх;	1.2.1. Төрийн үйлчилгээний албан ёсны жагсаалтыг гарган, төрийн үйлчилгээний стандартыг боловсруулах;	IV		Төрийн 320 үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлнэ	Төрийн үйлчилгээний цахим мэдээллийн төв байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна	30
5		1.2.2. Төрөөс үзүүлдэг үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээний байгууллага бүр тоо хэмжээ, цаг хугацаа, чанар, өртөг гэсэн үзүүлэлтээр үйлчилгээний стандарт тогтоож хэрэгжүүлэх;	IV		Төрийн 176 үйлчилгээг "ХУР" системд холбож төрийн үйлчилгээний чанар сайжруулна	Төрийн үйлчилгээний цахим мэдээллийн төв байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна	30

6	1.2. Иргэдийн хэрэгцээнд суурилсан төрийн үйлчилгээний стандартын тогтолцоог хөгжүүлэх	1.2.3. Анги дүүргэлт хэт өндөртэй сургууль, цэцэрлэгийн ачааллыг бууруулж, 3 ээлжтэй сургуулийг 2 ээлжинд шилжүүлэх;	III		Аймгийн хэмжээний бүх сургууль 2 ээлжинд шилжинэ	Боловсролын салбарт сүүлийн 3 жилд нийт 11.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. 2017 онд Булган сумын 150 хүүхдийн цэцэрлэг, 2018 онд 1280 суудалтай сургуулийн 2 шинэ барилгыг ашиглалтад хүлээн авлаа. Аймгийн хэмжээнд 22 сургууль байгаагаас Хутаг-Өндөр сумын сургуульд 1-р ангийн бүлгүүд гурван ээлжээр хичээллэж байна. Иймд 2019 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хичээлийн байрны барилгын өргөтгөл баригдаж ашиглалтад оруулахаар төлөвлөсөн. Тэшиг сумын сургуулийн хүүхдийн тооны өсөлтийн хэтийн төлөв нь 2019-2020 оны хичээлийн жилд 3-4 бүлэг 3 ээлжинд хичээллэх нөхцөл байдал үүсээд байна. Тэшиг сумын сургуулийн хичээлийн байрны өргөтгөлийн барилгын ажил хөрөнгө санхүүгээс шалтгаалан зогссон байгаа бөгөөд нэн даруй барилгын ажлыг гүйцээж, улсын комисст хүлээлгэн өгөх шаардлагатай байна.	70
7		1.2.4. Сурагчид дотуур байрандаа эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг сайжруулж, бага ангийн 6-8 настай хүүхдэд зориулсан асаргаа, халамж, хөгжлийн үйлчилгээ бий болгох;	IV		Рашаант, Бүрэгхангай сумдын ЕБС-ын дотуур байрны хангуулна	Аймгийн хэмжээнд нийт 26 дотуур байр байгаагаас стандарт хангасан 22 байр байна. Үүнээс инженерийн шугам сүлжээнд холбогдсон 10, нам даралтын уурын зуухтай 16 байр байна. 2018-2019 оны хичээлийн жилд аймгийн хэмжээнд нийт 1867 хүүхэд дотуур байранд амьдрах хүсэлт гаргаснаас 1775 хүүхэд хамрагдсан. Дашинчилэн, Рашаант сумд, Хялганат тосгоны сургуулийн дотуур байрыг шинээр барих барилгын зураг төсөв хийгдсэн. Үүнээс Рашаант суманд баригдах дотуур байрны барилгын ажлын 1.1 тэрбум төгрөгийн төсөв шийдэгдэж, барилгын ажил энэ онд хийгдэнэ. Бага ангийн 6-8 настай хүүхдэд зориулсан асаргаа, халамж, хөгжлийн үйлчилгээ бий болгох чиглэлээр сумдын сургуулиуд өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан дотуур байрны өрөө тасгийг гэрийн нөхцөлд ойртуулан тохижуулах чиглэлээр тодорхой ажлуудыг хийж байна. Тухайлбал: Орхон сумын сургуулийн дотуур байр төгсөгчид, малчидтай хамтран бүх тасгаа тохижуулаад байна. Цаашид дотуур байрны хатуу зөөлөн эдлэл, бусад тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах чиглэлээр шат дараалсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	70
8		1.2.5. Ахлах сургуулийн сурагчид сургуулиа төгсөөд сурах их дээд сургууль, мэргэжлээ зөв сонгох, элсэн суралцах бэлтгэлийг хангах талаар ажил мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг эхлүүлэх;	IV		10-12 дугаар ангийн 1466 суралцагчийг ажил мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээнд хамруулна	Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл"-ийн хүрээнд 2018-2019 оны хичээлийн жилд 10-12 дугаар ангийн сурагчдад "Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох" сургалтыг ерөнхий боловсролын сургуулиуд 7 хоног бүр зохион байгуулж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас 2019 оны 03 дугаар сарын 22-нд "Эерэг хандлага, хөгжил" сэдэвт лекц сургалтад 9-12 дугаар ангийн 210 суралцагч хамрагдсан.	70

9	1.3. Иргэн төвтэй төрийн үйлчилгээний менежментийг сайжруулах хөтөлбөрийг салбар бүр хэрэгжүүлэх	1.3.1. Байгууллага бүр үйлчилгээний менежментийг сайжруулах чиглэлээр хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;	I y		Байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмж сайжруулах төлөвлөгөө боловсруулсан байна	Аймгийн хэмжээнд 16 сум, 1 тосгоны Засаг даргын Тамгын газар болон төр, төсвийн байгууллагуудын төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, төрийн үйлчилгээг иргэдэд хурдан шуурхай хүргэх зорилгоор "Угтах үйлчилгээ"-г нэвтрүүлсэн. Аймгийн хэмжээнд 11 сум, 13 байгууллага "Хүлээж суулгүй, хүрч үйлчилье" нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулж, төрийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэсэн.	70
10		1.3.2. Үйлчлүүлэгчтэй харилцах нэгжийг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан бэхжүүлж, үйлчилгээний ажилтан, менежерийг чадавхжуулах, холбогдох сургалтад хамруулах;	IV		Хэрэгжилтийг хангаж ажиллах	2019 оны эхний хагас жилийн байдлаар 16 сум, 1 тосгон, 22 агентлаг, төр төсвийн байгууллагуудын дарга, захирал, эрхлэгч нарт ажлын байрны шинжилгээ хийх, гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, төрийн албан хаагчийн ёс зүйн талаарх сургалтыг Төрийн албаны зөвлөл, "Удирдлагын академи"-тай хамтран 3 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 680 албан хаагчийг хамрууллаа. 8 дугаар сард "Удирдлагын академи"-тай хамтран сумд, байгууллагуудын албан хаагчдад нэгдсэн сургалт зохион байгуулахаар төлөвлөөд байна.	30
11		1.4.1. Хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн үйлчилгээний стандартыг боловсронгуй болгох;	IV		Үйлчилгээний стандартыг мөрдүүлэх	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны "Хөгжлийн хөтөч /2016-2020 он/" хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдэд чиглэсэн бодлогын шинж чанартай арга хэмжээнүүдийг тусган хэрэгжүүлж байна. ХБИХ-ийн эрхийг хангах аймгийн салбар хорооноос энэ онд 4 зорилтын хүрээнд 22 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 20.5 сая төгрөгийг тусгасан. 2019 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд 37 төр төсвийн байгууллагад нийт 59 хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэд бүтцийн хүртээмж чанарыг сайжруулах үнэлгээний ажлын хэсэг аймгийн төвийн төрийн үйлчилгээ үзүүлж байгаа 27 байгууллага, хувийн хэвшлийн 25, нийт 52 байгууллагад үнэлгээ хийхэд 20 гаруй байгууллагын орчин нөхцөл сайжирсан байна.	70

12	1.4. Зорилтот бүлэгт чиглэсэн төрийн үйлчилгээг хөгжүүлэх	1.4.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн анхдагч мэдээллийн сан байгуулах	IV		Мэдээллийн санг жил бүр шинэчлэн бүрдүүлсэн байна	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх статистик тоон мэдээллийг сайжруулах зорилтын хүрээнд иргэдийн мэдээллийн нэгдсэн санг бий болгон, нас хүйс, өвчний онцлогоор нь ангилан мэдээ мэдээлэл цуглуулан эмхэтгэл гаргаж, салбар дундын хамтын ажиллагаанд ашиглах зорилт тавин ажиллалаа. 2019 оны эхний хагас жилийн байдлаар 62027 хүн амтайгаас 2341 хөгжлийн бэрхшээлтэй иргэн буюу нийт хүн амын 3.7 хувийг эзэлж байна. Эдгээр иргэдийн 1142 нь буюу 48.8 хувь нь эмэгтэй, 1199 нь эрэгтэй иргэн байна. Үүнээс 414 нь хүүхэд байгаа бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо сүүлийн үед өсөх хандлагатай байна. Байнгын асаргаа шаардлагатай 156 хүүхэд бүртгэлтэй байгаа ба хөгжлийн бэрхшээлийн дийлэнх хувийг саажилт, төрөлхийн оюуны болон мэдрэлийн өвчлөлүүд эзэлж байна. Байнгын асаргаа шаардлагатай хүүхдийн тоо өмнөх оноос буурсан шалтгаан нь байнгын асаргаа тогтоох шалгуур үзүүлэлт өндөр болсонтой холбоотой 105 хүүхэд асаргааны тэтгэмжээс хасагдсан байна. Хөдөлмөрийн чадвараа 50-69 хүртэл хувиар алдсан иргэн 51.4 хувийг, 70 буюу түүнээс дээш хувиар хөдөлмөрийн чадвараа алдсан иргэн нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 48.6 хувийг тус тус эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлийн төрлөөр авч үзвэл сэтгэц, оюуны хомсдол, дотор, харааны бэрхшээлтэй иргэд дийлэнх хувийг эзэлсэн үзүүлэлттэй байна. Орон нутгийн түвшинд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд тэгш оролцох боломжийг бүрдүүлэн дэмжиж, төрийн байгууллагад 57 иргэн, хувийн хэвшилд 59 иргэн ажиллаж хөдөлмөрлөж байна. Хувиараа бизнес, өрхийн аж ахуй, үйлдвэрлэл эрхэлж буй 134 иргэн байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 38.8 хувийг АБТДО-той өрхийн иргэд эзэлж байна.	100
13		1.4.5. Зорилтот бүлгийн хөгжил, амьжиргааны түвшний талаар цахим мэдээллийн сан бий болгож, тэдгээрийн хэрэгцээ, ур чадварт нийцүүлэн нийгмийн халамжийн дэмжлэг, үйлчилгээг үзүүлэх;	IV	Аймгийн төсөв 17.0 сая төгрөг	Зорилтот өрхийн хөгжлийг хамгаалах дэд хөтөлбөрийн хүрээнд 351 өрхөд нийгмийн халамжийн дэмжлэг үзүүлнэ	Манай аймагт нийт 19115 өрхийн 62027 хүн ам оршин сууж байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад өрхийн тоо 1.6 хувь, хүн амын тоо 1.4 хувиар тус тус өсчээ. Нийт хүн амын 31475 нь буюу 50.7 хувь нь эрэгтэй, 30552 нь буюу 49.3 хувь нь эмэгтэй байна. Нийт өрхийн 17.6 хувь нь аймгийн төвд, 30.2 хувь нь сумын төвд, 52.1 хувь нь хөдөөд амьдарч байгаа бөгөөд 5.5 хувь буюу 1035 нь нэн ядуу, 13.0 хувь буюу 2447 нь ядуу болон харьцангуй бага хэрэглээтэй өрхүүд байна. Өөрөөр хэлбэл амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхийн нийт өрхөд эзлэх хувь 18.2 хувь байна. Эдгээр өрхийн хүн амын мэдээллийн нарийвчилсан судалгааг 2017 оны 1-р улиралд ХНХЯ-аас зохион байгуулсан "Орлого орлуулан тооцож аргаар өрхийн амьжиргааны түвшин тогтоох" судалгааны дүнг үндэслэн аймгийн өрхийн мэдээллийн нэгдсэн санг үүсгээд байна.	70
14	1.6. Төрийн үйлчилгээг удирдах, хянах иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	1.6.1. Нийгмийн суурь үйлчилгээ үзүүлдэг төрийн зарим байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог бий болгох;	IV		Аймаг, сумдын иргэний танхимаар дамжуулан иргэний оролцоог хангана	Орон нутгийн удирдлагын болон төрийн захиргааны байгууллагуудаас гарч буй бодлого, шийдвэрт иргэдийн саналыг тусгахаар аймгийн Иргэний танхимтай хамтран хэлэлцүүлэг зохион байгуулж байна. 2019 оны хагас жилийн байдлаар 89 хэлэлцүүлэг зохион байгуулж, 3536 иргэнийг оролцууллаа.	100
2. ИЛ ТОД БАЙДАЛ, ИРГЭНИЙ ОРОЛЦООТой ШИЙДВЭР ГАРГАЛТ							

15	2.1. Шийдвэр гаргах үйл явцыг ил тод болгож, иргэдийн оролцоог хангах	2.1.1. Бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангаж, мэдээлэл ил тод, нээлттэй, хүртээмжтэй байх нөхцөлийг бүрдүүлэх;	IV		Цахимаар санал авах үйл ажиллагааг эхлүүлнэ	Аймгийн албан ёсны цахим хуудасны баяжилт шинэчлэлтийг тухай бүр хийж, 2019 оны эхний хагас жилд цаг үеийн мэдээ болон фото 89 мэдээ, видео 18 мэдээ бэлтгэн байршуулав. Сум, агентлагуудаас ирсэн онцлох мэдээ, цаг үетэй холбоотой зөвлөмж, үйл ажиллагааны тайланг www.bulgan.gov.mn хуудсаар дамжуулан иргэдэд мэдээлж байна. Бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, мэдээллийг ил тод, нээлттэй, хүртээмжийг нэмэгдүүлэхээр "Сайхан Монгол" орон нутгийн телевизтэй хамтран "Иргэдээ сонсье" шууд нэвтрүүлгийг Пүрэв гараг бүр 19.00 цагаас шууд нэвтрүүлж хэвшлээ. 2019 оны эхний хагас жилийн байдлаар 21 дугаарыг үзэгчдэд хүргэж, 78 иргэний санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэлээ.	100
16		2.1.2. Зөвлөлдөх ардчиллын санал асуулгыг нэвтрүүлэн иргэдийг тэнцвэртэй, үнэн зөв мэдээллээр ханган, шийдвэр гаргах түвшний иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;	IV		Хэрэгжилтийг хангаж ажиллах	Аймгийн хэмжээнд "Нээлттэй хаалга"-ын өдрийг "Хүлээж суулгүй хүрч үйлчилье" уриан доор 16 сум, төр, төсвийн 17 байгууллага зохион байгуулж, иргэдийг үнэн зөв мэдээллээр ханган, 258 иргэний санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэлээ. Төрийн зарим чиг үүргийн дагуу төрийн бус байгууллагуудаар 2019 онд гүйцэтгүүлэх 53 ажлын хүрээнд хагас жилийн байдлаар 35 төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж байна.	70
17	2.2. Төсөв, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх	2.2.1. Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь тогтмол мэдээлэх, хяналт, хариуцлагыг сайжруулах;	IV		Зөрчил, дутагдлыг багасгаж, гүйцэтгэлийг 99%-д хүргэнэ	Шилэн дансны мэдээлэл байршуулалт, тайлан илгээлт 99.0 хувьтай байна. Аймгийн хэмжээнд төсөвт байгууллага 176, сан 3, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 2, хувийн өмчийн аж ахуйн нэгж 71, орон нутгийн аж ахуйн тооцоот байгууллага 4 нийт 256 байгууллагын шилэн дансны мэдээлэл байршуулсан байдалд хяналт тавьсан. Нийт 31859 мэдээлэл мэдээлсэн ба 5122 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх улирлын мэдээлэл байршуулалт хангалтгүй байна.	100
18		2.3.1. Төрийн үйлчилгээг иргэнд хүргэх чиг үүрэг бүхий байгууллага өөрийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа дүрэм, журам, үйлчилгээний ажилтны чиг үүрэг, эрх хэмжээ, үйлчилгээ үзүүлэх хугацаа, бүрдүүлэх шаардлагатай материал зэрэг мэдээллийг нээлттэй хүргэж байх;	IV		Үзүүлэлтийг 96%-д хүргэнэ	Аймгийн хэмжээнд 11 сум, 13 агентлаг "Нэг цонхны үйлчилгээ" үзүүлж, Булган аймгийн албан ёсны вэб сайт www.bulgan.gov.mn сайтыг Монгол улсын Засгийн газрын www.zasag.mn сайттай холбосон ба албан ёсны баяжилт шинэчлэлтийг хийж татвар, улсын бүртгэл, газрын харилцаа, нийгмийн даатгал, нийгмийн халамжийн чиглэлийн үйлчилгээг авах материалын дэлгэрэнгүй мэдээллийг тус сайтаас авах боломжтой болсон. Иргэдэд төрийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэж байна.	70

19	2.3. Байгууллагын ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлэх	2.3.2. Иргэн, хуулийн этгээдэд хэрэгцээтэй, тэдэнд хамаарах шийдвэрийг цахим хуудас болон бусад хэлбэрээр нийтэд мэдээлж хэвших;	IV		Цахим хуудсанд мэдээлэх ажлыг 30 хувиар нэмэгдүүлж, сумд, байгууллагууд нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулна	Төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж болон шинээр мөрдөгдөж байгаа хуулиудыг онцлон 16 сум, 1 тосгон, төрийн байгууллагуудын цахим хуудсаар дамжуулан шторк 9, слайд 20, сургалт, сурталчилгааны богино хэмжээний 29 төрлийн киног эрх зүйн мэдлэг, мэдээлэл олгох цахим мэдээллийн сан бүхий "э-хөтөч" портал сайтад байршуулан мэдээлж байна. Аймгийн гэр бүлийн 106.5 FM радиотой хамтран ажиллаж 7 хоногийн 2 өдөр "Хуулийн цаг" шууд нэвтрүүлгийг явуулж хэвшээд байна. 16 сум, төр, төсвийн 17 байгууллага "Нээлттэй хаалга"-ны өдрийг зохион байгууллаа.	70
20		2.3.3. Иргэнээс гарах үйл ажиллагааны зардал, төрийн үйлчилгээ авах цаг хугацааг бууруулах зорилгоор шат дамжлагыг цөөлөх, үйл ажиллагааг оновчтой болгоход чиглэсэн дүрэм, журмыг хянан үзэж өөрчлөх, хүчингүй болгох арга хэмжээ авах;	II		Дүрэм, журмын холбогдох заалтыг оновчтой болгоно	Аймгийн ИТХ, Тэргүүлэгчид, аймгийн Засаг даргаас 2012-2018 онд гаргасан шийдвэрүүдэд судалгаа хийж 123 шийдвэрт өөрчлөлт оруулах саналыг боловсруулан. Хуулиар олгосон эрх хэмжээ нь хэтэрсэн, ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан 12 шийдвэрийг хүчингүй болгож, холбогдох хуулиудад нийцүүлэн батлуулах талаар холбогдох хэлтсүүдэд зөвлөмж, чиглэлийг өгч хэрэгжилтийг хангасан.	100
21		2.3.4. Байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаа нь тухайн байгууллагын ажилтнуудад нээлттэй байх, шийдвэрийн үндэслэлийн талаарх мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд нээлттэй болгох.	IV		Хэрэгжилтийг 100%-д хүргэнэ	Булган аймгийн албан ёсны цахим хуудас www.bulgan.gov.mn-д хүний нөөцийн ил тод байдлыг хангах холбоосыг үүсгэн мэдээллийг тогтмол шинэчилэн ажиллаж байна. Аймгийн Засаг даргын А/342, Б/50 дугаар захирамж, Тамгын газрын даргын А/44, Б/55 тоот тушаал хүний нөөцийн удирдлагатай холбоотой шийдвэрийг тухай бүр ил тод байрлуулан мэдээлж байна. Аймгийн хэмжээнд төрийн жинхэнэ албан тушаалын гүйцэтгэх албан тушаалын сул орон тооны зарыг Булган аймгийн албан ёсны цахим хуудас www.bulgan.gov.mn-д байршуулсан. Дээрх сул орон тоог нөхөх мэргэшлийн шалгалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх мэргэшлийн шалгалтын төв комисст хүргүүлэн www.csc.gov.mn –д тус тус байрлуулсан.	70
22	2.4. Мэдээлэл хүргэх оновчтой тогтолцоог бий болгох	2.4.2. Төрийн байгууллагуудаас иргэн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх мэдээллийн системд танилт нэвтрэлтийн нэгдсэн ДАН системийг холбох;	II		Цахим хэлбэрээр үзүүлэх Төрийн үйлчилгээг нэмэгдүүлнэ	Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс ДАН системд холбогдон төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж байна.	30
3. ОНОВЧТОЙ ЧИГ ҮҮРЭГ							

23	3.2. Чиг үүргийн дахин хуваарилалтыг хийж, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох	3.2.1. Төвлөрлийг сааруулах, төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор төрийн захиргааны болон нутгийн удирдлагын байгууллагын чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийж, чиг үүргийг дахин хуваарилах;	IV		Төрийн байгууллагын чиг үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхой болгоно	Төрийн байгууллагын албан хаагчдад ажлын байрны шинжилгээ хийх сургалтыг зохион байгуулсан. Төрийн байгууллага бүр чиг үүргийн шинжилгээ хийж, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж байна. Аймгийн хэмжээнд 148 байгууллага 3027 төрийн үйлчилгээний албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн баталсан.	30
24		3.2.2. Орон нутгийн хөгжлийн загварт тулгуурлан нийгмийн үйлчилгээний жишиг нормативыг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг жигд хүртээмжтэй болгох.	IV		Хэрэгжилтийг хангаж ажиллах	Хугацаа болоогүй	ХТХБ
4. ҮР ДҮНД СУУРИЛСАН УДИРДЛАГА							
25	4.1. Гүйцэтгэлийн үнэлгээгээр хувь хүний өрсөлдөх чадварыг хөхиүлэн дэмжих	4.1.1. Үр дүнд суурилсан удирдлагын хяналт, шинжилгээ, үнэлгээний системийг нэвтрүүлэх;	IV		Бодлого төлөвлөлт, төсөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөө нэмэгдсэн байна	Бодлогын баримт бичиг, хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сум, байгууллагуудаас ABLE программаар авч хэвшсэн. Ингэснээр мэдээ, тайлангууд цаг алдалгүй хугацаандаа ирж, түүний мөрөөр засаж сайжруулах зөвлөмжийг нэгж байгууллагад хүргүүлэн цаашдын үйл ажиллагаандаа тусгаж ажиллах нөхцөл бүрдсэн.	30

26	4.2. Гүйцэтгэлийн үнэлгээг сайжруулж, олон тулгуурт хяналтын тогтолцоог хөгжүүлэх	4.2.1. Төрийн байгууллагын үйл ажиллагааг бус үр дүнг үнэлдэг үнэлгээний тогтолцоог хөгжүүлэх; (иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг нэвтрүүлж төрийн бодлогын үр дүн, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг хараат бусаар үнэлж, дүгнэн зөвлөмжийн дагуу хариу арга хэмжээ авч ажиллах соёлыг хэвшүүлэх)	IV	Засаг даргын нөөцийн хөрөнгө 7.7 сая	Хэрэгжилтийг хангаж ажиллах	Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасны дагуу төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн болон иргэдэд хүргэдэг үйлчилгээ чанартай, хүртээмжтэй, хүнд сурталгүй шуурхай байгаа эсэх талаар иргэдийн хандлагыг тандан судалж, түүнд дүн шинжилгээ хийн, цаашдын бодлого, төлөвлөгөөнд тусгах зорилгоор иргэдээс хэрэглэгчийн үнэлгээний судалгаа авах ажлыг зохион байгууллаа. Тус судалгааг "Булган Манлайлал-Шийдэл" төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэв. Судалгаанд 10 сумын 825 иргэн хамрагдсан бөгөөд хэрэглэгчийн үнэлгээ 2018 онд 53.0 хувьтай гарсан байна. Хэрэглэгчийн үнэлгээний судалгааны үр дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн үнэлгээний мөрөөр ажил сайжруулах төлөвлөгөө гарган ажиллалаа.	100
27		4.2.2. Иргэдийн сэтгэл ханамжийн үндэсний индекстэй болох;	III		Иргэдийн сэтгэл ханамжийг 60%-д хүргэнэ	Хугацаа болоогүй	ХТХБ
28		4.2.3. Төрийн үйлчилгээнд иргэдийн үнэлгээний картын системийг нэвтрүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх.	IV		Хуулийн төсөлд саналаа хүргүүлнэ	Хугацаа болоогүй	ХТХБ
5. ИРГЭН ТӨВТЭЙ МЭРГЭШСЭН ТӨРИЙН АЛБА							
29		5.1.1. Иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулахдаа хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах зарчмыг тууштай хэрэгжүүлэх;	IV		Төрийн албаны тухай хуулийн "Чадахуйн зарчим"-ыг хэрэгжүүлнэ	Төрийн албанд иргэнийг сонгон шалгаруулах, шатлан дэвшүүлэх ажлын бэлтгэл ажлыг ханган, төрийн албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж байна. Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан төрийн байгууллага бүр ажлын байрын шинжилгээ хийж, албан тушаалын тодорхойлолтыг шинэчилж байна. Аймгийн хэмжээнд 512 төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтын төслийг боловсруулан Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн хянуулахад бэлэн болоод байна.	70

30	5.1. Төрийн албаны хүний нөөцийн төлөвлөлтийг хөгжүүлж, сургалт хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх	5.1.3. Төрийн албан хаагч тогтвортой ажиллах, төрийн алба хаших шалгуур нь зөвхөн мэргэшлийн болон уг албыг гүйцэтгэх мэдлэг чадвар, мэргэжлийн ёс зүйгээр тодорхойлогддог байх нөхцөлийг бүрэн хангах;	IV		Мэргэшсэн албан хаагчдын тоо 50-аас доошгүй хувьд хүргэнэ	Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг баримтлан төрийн байгууллагууд "Ёс зүйн зөвлөл"-ийг шинэчлэн ажиллаж байна. Ёс зүйн зөвлөлүүд байгууллагын хэмжээнд албан хаагчдын гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажлуудыг санаачлан хэрэгжүүлж байна. Тухайбал: Төрийн байгууллага бүр албан тушаалын тодорхойлолтод ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллах талаар тусгасан. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар, Булган, Сэлэнгэ сумын ЗДТГ соён гэгээрүүлэх нөлөөллийн сургалтыг сар тутам зохион байгуулж, албан хаагч нэг бүртэй сахилга, ёс зүйн гэрээг байгуулан хэрэгжилтэд хяналт тавьж байна. Сэлэнгэ сум төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг хэлэлцэн, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллах талаар үүрэг даалгавар өгсөн.	70
31	5.2. Цалин хөлс, урамшуулал, нийгмийн баталгаа	5.2.4. Төрийн албан хаагчийн орон сууцны хөтөлбөрийг баталж, орон сууцаар хангагдах нөхцөлийг бүрдүүлэх;	II		Төрийн албан хаагчдын орон сууцны нөхцөлийг сайжруулна	Төрийн албан хаагчийн хүний нөөцийн системийн тайланд үндэслэн Булган аймгийн төрийн албан хаагчдын орон сууцны судалгааг урьдчилсан байдлаар гаргалаа. Судалгаагаар нийт төрийн албан хаагчдын 21.9 хувь нь орон сууцанд, 66.2 хувь нь хашаа байшинд, 2.4 хувь нь гэрт, 5.1 хувь нь түрээсийн орон сууцанд, 4.1 хувь нь бусдын орон сууцанд амьдарч байна. Булган сумын 6 дугаар багт төрийн албан хаагчдад зориулсан 320 айлын орон сууц барих зориулалттай газрыг аймгийн Засаг даргын Тамгын газрын мэдэлд шилжүүлсэн. Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний зураг төслийг боловсруулж байна.	30
32	5.3. Ажлын байрны шинжилгээ, үнэлгээ	5.3.1. Ажлын байрны шинжилгээг хийж, тухайн ажлын байранд тавигдах шалгуурыг тодорхой тогтоох, ажил үүргийн давхардал, хийдлийг арилгах, цалин хөлсний системийг боловсронгуй болгох, ажилтнуудын сургалтын хэрэгцээг тодорхойлох, ажилтнуудын ачааллыг тэнцвэржүүлэх арга хэмжээ авах.	II		3872 албан хаагчийн ажлын байрны шинжилгээ хийгдэж, ачааллыг тэнцвэржүүлэн, ажлын үр нөлөөг нэмэгдүүлнэ	Удирдлагын академитай хамтран "Ажлын байрны шинжилгээ хийх арга зүй" сургалтыг зохион байгуулж бүх шатны төрийн байгууллагын дарга, удирдах албан тушаалтан, дотоод ажил хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулсан. Төрийн байгууллага бүр ажлын байрын шинжилгээ хийж, албан тушаалын тодорхойлолтыг шинэчилж байна. Аймгийн хэмжээнд 512 төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтын төслийг боловсруулан Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн хянуулахад бэлэн болоод байна. 3027 төрийн үйлчилгээний албан тушаалыг эрх бүхий байгууллага, албан тушаалтан шинэчлэн баталсан.	70
Нэгдсэн дүн:							65.2